

Дэлгэрцогт сумын нийт нутаг дэвсгэрийг хамарсан малын сэг зэм устгасан ажлын тайлан

2018.05.26

Амардалай.

2018 оны 04-р сарын 04, 11 ны цасан шуурга болон шороон шуурганд уруудаж үхсэн мал, хаврын өлдөж муудсан малын сэг зэм устгах ажлыг сумын хэмжээнд зохион байгуулахаар Сумын Засаг Даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн А/42 тоот захирамжаар “Мал амьтаны сэг зэмийг устгах ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй томилж Баянбулаг, Цахиурт, Дэлгэр-Эмт багын засаг дарга нар багуудын нутаг дэвсгэрээр явж үхсэн мал амьтны сэг зэм байгаа газрын зураглал, тоо хэмжээг тогтоож ажилласан.

05 дугаар сарын 17 ны өдөр 3-р багийн Засаг Дарга П.Түвшинсайханаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй 2 техниктэй ажлын хэсэг гарч сумын төв болон тухайн багын нутаг дэвсгэрт байгаа үхсэн мал амьтны сэг зэмийг ачиж ,бод 42, бог 169, нийт 211 сэг зэм нохой 2, зээр 11, зээрийн арьс 32 ш-ийг ачиж зөөн устгалын нүхэнд хийсэн байна. Нийтдээ 3 машин сэг зэмийг ачиж буулгаж буллаа.

05-р сарын 18,19 ний өдрүүдэд Баянбулаг багийн нутаг дэвсгэрт Багийн Засаг Дарга П.Мөнхзоригор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж, 4 машин сэг зэмийг устгах ажил хийж гүйцэтгэлээ. Үүний 2 машин сэг зэм нь сумын хогийн цэг дэх устгалын нүхэнд, 2 машин нь Цахиурт багийн нутаг дахь Хаяагийн устгалын нүхэнд хийсэн байна. Баянбулаг багийн нутаг дэвсгэрээс 53 бод, 104 бог нийт 157 сэг зэмийг устгасан.

05 дугаар сарын 20,21,22,23,24 өдрүүдэд Цахиурт багын Засаг даргаар ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй 3 техниктэй ажлын хэсэг гарж зээр 1, үнэг 1, бод 167, бог 478 нийт 645 сэг зэмийг устгасан. Тухайн сумын сэг зэм булах нүхийг Хятадын компанид ажиллаж байгаа экскаватораар 5*5 харьцаатай доошоо 4 метрийн гүн нүхийг Цахиурт багын нутаг Е106 17 28.9 N46 29 27.9 болон Дэлгэр-Эмт багын нутаг Е106 23 57.7 N46 06 26.9 гэсэн координаттай газруудад устгалын цэгийг байгуулж байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр ухуулсан. Сумын хэмжээнд нийт 1.500.000 төгрөгний санхүүжилтээр 2 машин, 3 мотоцикл 2 ачигч 1 жолооч, багын дарга нарын бүрэлдэхүүнтэй бог болон бод малын сэг зэм 761 бог 599 бод нийт 1360 малын сэг зэм нохой 2, зээр 12, үнэг 1, зээрийн арьс 32 зэргийг устгалын нүхэнд хийж буллаа. Нэмэлт санхүүжилтээр ирсэн төсвийн 400100 төгрөгийг ажлын хөлс, бусад зардалд, 1099900 төгрөгийг шатахууны зардалд зарцууллаа.

Устгалын нүх



Малын сэг зэм ачиж буй байдал





Тайлан бичсэн

МЭҮТ-ийн мэргэжилтэн

/Ө.Дугармаа /